

2016-05-12

Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 4-р сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 4 дүгээр сард 348 байгаагийн 193 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63 буюу 15.3 хувиар буурч, өмнөх сарынхаас 62 буюу 21.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын бүртгэл, статистикийн газрын Бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 4 дүгээр сарын байдлаар 144 эх амаржиж, 145 хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 17 буюу 13.4 хувиар, төрсөн хүүхдийн тоо 17 буюу 13.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



II. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 4 дүгээр сард 1996.5 сая төгрөг, зарлага 2754.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 345.7 сая төгрөг буюу 14.7 хувиар буурч, зарлага 54.4 сая төгрөг буюу 2.0 хувиар өслөө. Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 4 сард 3236 хүнд 465.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 209 хүн буюу 6.9 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 7.1 сая төгрөг буюу 1.5 хувиар тус тус өссөн байна.



III. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 4 сарын байдлаар 135 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 134 үүнээс 67 нь хүү, 67 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 5 буюу 3.8 хувиар, төрсөн хүүхэд 6 буюу 4.7 хувиар тус тус өссөн байна. Он гарсаар 46838 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 12059 буюу 34.7 хувиар, 1755 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 266 буюу 17.9 хувиар тус тус өссөн байна.



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 4 сард 65 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3 хэрэг буюу 4.4 хувиар буурсан байна. Илрээгүй гэмт хэргийн тоо 11, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 68.6 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс илрээгүй гэмт хэрэг 1 буюу 8.3 хувиар, илрүүлэлтийн хувь 0.9 пунктээр тус тус буурсан байна. Гэмт хэргийн улмаас 60 хүн гэмтэж, 8 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 29 буюу 32.6 хувиар буурч, нас баралт 1 буюу 14.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 4 дүгээр сард өмнөх сарынхаас 2.3 хувь, өмнөх оны эцсийнхээс 2.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.2 хувиар өссөн байна.



VI. Орон нутгийн төсөв

2016 оны эхний 4 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 5105.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 5406.1 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 1512.5 сая төгрөг буюу 38.8 хувиар өсчээ. Аймгийн төсвийн нийт зарлага 5331.7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 4184.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 1147.1 сая төгрөгийн хэмнэлттэй байна.



VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлэгч малын 138714 буюу 81.0 хувь нь 2016 оны 4 дүгээр сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 87.6 хувь, эм ямаа 80.4 хувь, үнээний 51.2 хувь, ингэний 34.7 хувь, гүүний 27.8 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 139610 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 20392 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна.



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 4 сард 15477.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3141.3 сая төгрөг буюу 25.5 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 3045.4 сая төг буюу 26.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 14322.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1139.8 сая төгрөг буюу 8.6 хувиар өслөө. Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 14322.5 сая төг буюу 93.3 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.

Материал бэлтгэсэн: Мэргэжилтэн.....С.Эрдэнэзаяа